



# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### “Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСАТАГ-2019/2/СТА-ЗГТС

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойр хот

2018 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 70543156

Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 70543179

Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn

Аудитор: Б.Анхтуяа

Утас: 70543179

Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ	
2	Аудитын тайлан	
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8-9
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11-15



## 1 Аудитын гэрчилгээ



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2019.02.22 № 26  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ХАЛАМЖИЙН САНГИЙН  
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Д.ГАНСҮХ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Халамжийн сан"-гийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Говьсүмбэр аймгийн "Халамжийн сан"-гийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Говьсүмбэр аймгийн "Халамжийн сан"-гийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус санд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТ ОРГОН Б.САРАНТУЯА



## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн захирагч Д.Гансүхэд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-гийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан” нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.15-наас 2019.02.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Анхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар-т 2019.01.31-ний өдрийн №01/89 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.



### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-гийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан” нь “Нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, нийгмийн тогтвортой хөгжлийн бодлогыг орон нутагтаа хэрэгжүүлэн ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-гийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр нийгэм халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллах

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан” нь үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн



байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журам, зааврууд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант хугацаанд эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт хийгдээгүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-гийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан” нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Интерактив” ХХК-ийн санхүүгийн програм ашиглаж байгаа бөгөөд Халамжийн сангийн тэтгэвэр тэтгэмжийн олголтыг WAIS.HUDULMUR-HALAMJ.GOV.MN программ хангамж, Халамжийн сангийн санхүү бүртгэл нь FINANCE.HUDULMUR-HALAMJ.GOV.MN хаягаар цахимаар хандалт хийн интернэт орчинд ажилладаг 2 программ” хангамж ашигладаг байна.

Говьсүмбэр аймгийн Халамжийн сан дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-гийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн





үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт “зардал”-ын 1 хувиар сонгов.

“Нийт зардал”-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Материаллаг байдлын суурийг үр дүнгийн тайлангийн зардлаас тооцох нь оновчтой гэж үзсэн юм.

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-гийн 2018 оны нийт зардал 2,181,073.9 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 21,810.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь өмнөх аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан, эрсдэл багатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 1 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.



Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	0	0.00	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

**2.8.1.1. Орлогын данстай холбоотой асуудал**

Арилжааны банкны буруутай үйлдлээс шалтгаалан одон сангийн хүүгийн орлого 81.1 мянган төгрөгийн төвлөрүүлэлтийг данс андуурч гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь Санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Гүйцэтгэлийн аудитаар хөтөлбөр тус бүрээр зарцуулсан зардлыг үйл ажиллагааны үр дүн, үр ашигтай уялдуулан нарийвчлан үзэх шаардлагатай.

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.



“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-гийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 2,160,492.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,979,205.4 мянган төгрөг буюу 91.6 хувьтай байгаа нь төлөвлөснөөс илүү төсөв батлагдсантай холбоотой юм.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллийн 2 нь хугацаа болоогүй ба нийт оруулсан мэдээллийн 2 буюу 1.4% нь хугацаа хоцорч оруулсан мэдээлэл байна. Цаашид шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулан ажиллах нь зүйтэй.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Говьсүмбэр аймгийн Халамжийн сан”-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Говьсүмбэр аймгийн Халамжийн сан” нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



### 3 Менежментийн захидал

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Говьсүмбэр аймгийн Халамжийн сан” нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар материаллаг хэмжээний зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөгдөөгүй болно.



#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>346186.98</u></b>	<b><u>0.00</u></b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	206186.98	0.00
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	206186.98	0.00
3121	<b>Төгрөг</b>	206186.98	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	206186.98	0.00
33	<b>АВЛАГА</b>	140000.00	0.00
336	<b>Зээлийн авлага</b>	140000.00	0.00
3361	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	140000.00	0.00
33611	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	140000.00	0.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>346186.98</u></b>	<b><u>0.00</u></b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>346186.98</u></b>	<b><u>0.00</u></b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	346186.98	0.00
413	<b>Өглөг</b>	346186.98	0.00
4136	<b>Бусад өглөг</b>	346186.98	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	206186.98	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	140000.00	0.00
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>346186.98</u></b>	<b><u>0.00</u></b>



4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1545407580.79</b>	<b>2181073869.14</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4196980.79</b>	<b>20581669.14</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4196980.79	20581669.14
120002	Хүүгийн орлого	4196980.79	4987623.85
120009	Бусад орлого		15594045.29
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1541210600.00</b>	<b>2160492200.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	281280000.00	836500000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	281280000.00	836500000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1259930600.00	1323992200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1259930600.00	1323992200.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1545787580.79</b>	<b>2181073869.14</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1545787580.79</b>	<b>2181073869.14</b>
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1545787580.79	2181073869.14
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1381859188.99	1979325370.36
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1381859188.99	1979325370.36
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4463049.44	179150384.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4463049.44	179150384.43
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	159465342.36	22598114.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	159465342.36	22598114.35
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-380000.00</u></b>	<b><u>0.00</u></b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-380000.00</u></b>	<b><u>0.00</u></b>



4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А  
/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1545896517.80</u></b>	<b><u>2182532689.14</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,685,917.80</b>	<b>22,040,489.14</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,685,917.80	22,040,489.14
120002	Хүүгийн орлого	4,685,917.80	4,987,623.85
120009	Бусад орлого		17,052,865.29
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,541,210,600.00</b>	<b>2,160,492,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	281,280,000.00	836,500,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	281,280,000.00	836,500,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,259,930,600.00	1,323,992,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,259,930,600.00	1,323,992,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,563,224,360.57</u></b>	<b><u>2,182,738,876.12</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,563,224,360.57</b>	<b>2,182,738,876.12</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,563,224,360.57</b>	<b>2,182,738,876.12</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	1,980,784,190.36
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		1,980,784,190.36
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	282,163,657.34	22,607,811.19
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	277,591,000.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,572,657.34	22,607,811.19
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,281,060,703.23	179,346,874.57
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,114,963,316.00	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	166,097,387.23	179,346,874.57
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>17,327,842.77</u></b>	<b><u>206,186.98</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	17,327,842.77	206,186.98
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	17,534,029.75	206,186.98
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	206,186.98	0.00



4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			0.00		0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00		0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			0.00		0.00
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00





4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1541210600.00	1380876186.00	2160429200.00	1979205370.36
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1541210600.00	1380876186.00	2160429200.00	1979205370.36
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1541210600.00	1380876186.00	2160429200.00	1979205370.36
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1541210600.00	1380876186.00	2160429200.00	1979205370.36
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1541210600.00	1380876186.00	2160429200.00	1,979,205,370.36
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1541210600.00	1380876186.00	2160492200.00	1979205370.36
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1541210600.00	1380876186.00	2160492200.00	1979205370.36
131001	Улсын төсвөөс санхүүжих	1541210600.00	1380876186.00	2160492200.00	1979205370.36
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		17534029.75		206186.98
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		206186.98		0.00